

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГИЙН СУДАЛГАА

Г. Дүгэржав, МУБИС

Abstract

Adolescence is a transitional stage of physical and psychological human development that generally occurs during the period from puberty to legal adulthood. The period of adolescence is most closely associated with the teenage years, though its physical, psychological and cultural expressions may begin earlier and end later.

A thorough understanding of adolescence in society depends on information from various perspectives, including psychology, biology, history, sociology, education, and anthropology.

All teenagers are different for the spending free time. Some of them usually spend an increasing amount of their free time in structured extracurricular activities such as arts and sports. But many of them spend their free time doing things like shopping, going to parties, being with friends, using technology for games or other online activities, social networking, texting, and watching movies.

The survey comprised totally 90 students from 3 secondary schools in UB. The result of the survey shows that the teenagers spend much of their free time using media, watching television, particularly travelling on the internet. At the time the teenagers need the special policy to spend the leisure time from their teachers, parents, schools.

Түлхүүр үг

Хүүхэд, өсвөр нас, өсвөр насны хүүхдийн чөлөөт цаг, техник технологи

Удиртгал

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцэд “0-18 насны бүх хүнийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд өнөөдөр манай улс 1.136 мянга буюу нийт хүн амын 40 гаруй хувийг хүүхэд эзэлж байна.

“Хүүхэд” эх орны хувь заяа, ирээдүйн болон өнөөдрийн дүр зураг төдийгүй юугаар ч сольшгүй үнэт баялаг, үндэсний алтан нөөц, нийгмийн бүтээгдэхүүн юм. Тийм ч учраас төр, засаг улс орныхоо хөгжлийн баттай тулгуур болох хүүхдийг өв тэгш хүмүүжилтэй, өндөр боловсролтой, соёл, зан заншлаа өвлөсөн, чадварлаг залуу үе болгон төлөвшүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээгээр тэгш хангахад анхаарч, хамтын чармайлтыг хөгжүүлэхийг эрхэмлэдэг.

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинжлэх ухаан мэдээллийн технологийн салбарын хурдтай хөгжил, Улаанбаатар хотын хүн амын нягтрал зэргээс хамааран хүмүүсийн амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт гарч байна.

Техник технологи хурдацтай хөгжиж байгаа энэ цаг үед өсвөр насны хүүхдүүд ихэнх цагаа зурагт, компьютер, гар утастайгаа өнгөрөөж байна.

Өсвөр насны хүүхдийн хамгаалал, бие бялдрын хөгжил, эрүүл мэнд талаас нь үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэмтэн судлаачид судалжээ. Тухайлбал, Монголын Үндэсний Статистикийн

Газраас Монгол Улсын засгийн газар болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (2004-2005),

- НҮБ-ын салбар ДЭМБ-аас өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлтийн судалгаа, (2013),
- Үндэсний цөөнх “цаатан” хүүхдийн сурч боловсрох эрхийн судалгаа, орон гэрээсээ дайжсан хүүхдийн судалгаа, боловсрол эзэмшилтийн болон жендерийн судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа зэргийг үндэсний хэмжээнд явуулсан.

Мөн манай үндэсний статистикийн газрын 2015 оны 11 дүгээр сарын мэдээгээр хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 87 хэргээр буюу 9,1% -аар өссөн үзүүлэлт гарчээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1229 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 365 хэргээр буюу 42,2% -аар өссөн байна.

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн үнэт зүйл алдагдаж байгаагаас эцэг эх, үр хүүхэд бие биеэ үл хүндэтгэх, гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл, гэмт хэрэг гарах зэрэг сөрөг үзэгдлүүд гарч байна. Гэр бүлийн харилцааны сөрөг нөлөөнд хамгийн их хэлмэгдэгсэд нь хүүхдүүд бөгөөд хүүхэд хүнд, хүчир хөдөлмөр эрхлэх, гэр орноосоо дайжих,

гэмт хэрэг үйлдэх, архи, тамхи, мансууруулах бодисын нөлөөнд автах зэрэг ноцтой хохирлууд амсаж хүүхэд насаа золиосолж байна.

Дээрх судалгаанаас харахад өсвөр насны хүүхдийн гэмт хэрэгт холбогдох шалтгааны нэг нь хүүхдийг халуун дулаан, амар тайван угтах ёстой гэр оронд нь хүчирхийлэл, айдас түгшүүр угтахад өсвөр насны хүүхдүүд ямар байдалтай, юу хийж өдөр хоногийг хаана өнгөрүүлэх вэ? Тэд чөлөөт цагаараа хаана юу хийж явна? гэх мэт олон асуултууд гарч байна. Монголд сүүлийн жилүүдэд залуучууд болон өсвөр насны хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрөөх газар хомс хэвээр байна.

Ихэнх хүүхдүүд фейсбүүкээр өдөр, шөнөгүй хэсэж инстаграмдаа элдэв хэв маягийг илэрхийлсэн зургаа тавьж, хэдэн зуун, мянган найзтай, дагагчтай, тэдэнтэйгээ хэрэгтэй, хэрэггүй мэдээлэл хуваалцаж чихэвч зүүсэн анир чимээгүй, амьд бус харилцаанд оршиж байна. Зарим хүүхдүүд хий дэмий гадуур сэлгүүцэн, гэмт хэрэгт холбогдох нь ихэс ч, зарим нь өөрсдийгөө, ар гэрээ тэжээхийн тулд хөдөлмөр эрхэлж байна.

Дээрх судалгаа нь ирээдүйд улс үндэстнээ удирдан авч явах хойч үеийнхнийгээ хэрхэн төлөвшиж буйд эцэг эх, боловсролын салбарынхан төдийгүй бодлого тодорхойлогчид анхаарах тулгамдсан асуудал гэдгийн илэрхийлэл болж байна.

Өсвөр насны тухай ойлголт

Юун түрүүн өсвөр насны тухай ойлголт, түүнийг олон улсад болон судлаачид хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Adolescence нь *adolescere* гэдэг латин *гаралтай to grow- өсөх гэсэн утгатай үг юм*. Өсвөр нас гэдэг нь ерөнхийдөө бэлгийн бойжилтоос насанд хүрсэн хүн болох үеийг хамарсан биеийн болон сэтгэлзүйн хөгжлийн шилжилтийн үеийг хэлнэ. Өсвөр нас нь 13-19 насны хооронд илрэх бөгөөд бие сэтгэлзүй, соёлын шинжүүд нь эрт, хожуу янз бүрийн хугацаанд илэрч болох юм. Нийгэм дэх өсвөр насныхны талаарх бүрэн төгс ойлголт нь хүн судлал, социологи, түүх, биологи болон сэтгэл судлалыг багтаасан олон чиглэлийн мэдээллээс хамаарах юм.

Өсвөр нас гэдэг нь зан чанар, оюун ухаан, бие бялдрын зэрэг өөрчлөлтүүдийг багтаасан хүүхэд насан хүрэгч хоёрын хоорондын хөгжлийн шилжилтийн үе юм.

Өсвөр насны (12-16 нас) хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахууны төлөвшил, ертөнцийг үзэх үзэл, бусадтай харилцах харилцаа, хандлага зэрэг бүх зүйлд ихээхэн өөрчлөлт гардаг гэж (Ичинхорлоо, 2012, х.38)

үзсэн байна.

“БИ” үзэл /egocentrism/ хүчтэй хөгжиж, өөртөө дүн шинжилгээ хийх, өөрийгөө бусадтай жиших, өөрийгөө үнэлэх зэрэг шинэ бүрдлүүд бий болдог.

Уг насны хүүхдийн голлох үйл ажиллагаа бол найз нөхөхтэйгөө ойр дотно харьцаа тогтоох явдал юм. Энэ насныхны сэтгэл санааг зовоодог гол асуудал бол Би гэж хэн бэ? Би цаашид хэн болох вэ? Би бусдад ямар харагдаж байгаа бол? зэрэг асуулт юм.

Энэ үед хүүхдэд өөрийгөө нээн илрүүлэх бусадтай харьцах зэрэг нэн чухал хэрэгцээ бий болдог. Өсвөр насанд бий болдог дараагийн шинэ бүрдэл бол хүмүүст, нийгмийн бусад үзэгдлүүдэд шүүмжлэлтэй хандах хандлага бий болдог (Ичинхорлоо, 2012) нь гэж үзсэн байна.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ДЭМБ-ын тодорхойлолтоор өсвөр нас гэдэг нь хүүхэд ахуй нас ба орь залуу насны хооронд орших үе шат бөгөөд 10-19 насыг багтаан үзсэн байна. Шилжилтийн гэж нэрлэхийн учир нь:

1. Хүүхдийн физиологийн хөгжил, бэлгийн бойжилт эрчимтэй явагдан бэлгийн хоёрдогч шинж тэмдгүүд илрэн охид эмэгтэй хүний, хөвүүд эрэгтэй хүний намба төрхтэй болно. Бэлгийн сонирхол, хүсэл тэмүүлэл үүсэж “Хүүхдийн” гэсэн бүхнээс тусгаар байхыг эрмэлзэнэ.
2. Сэтгэл зүйн хувьд хүүхэд өөрийгөө “том хүн” боллоо хэмээн бодож “Насанд хүрсэн хүний” байр сууринаас аливаад хандахыг эрмэлзэнэ. Энэхүү мэдрэмжийн илрэл нь:
 - Насанд хүрэгчдийн гадаад онцлог шинж, төрхийг дуурайх
 - Нийгэмшихүйн хүрээнд дээрх мэдрэмж нь насанд хүрэгч ба өсвөр насныхны хоорондын хамтын ажиллагааны явцад илрэх
 - Оюун ухааны хүрээнд дээрх мэдрэмж нь мэдлэг чадвараа нэмэгдүүлэх гэсэн хүсэл тэмүүлэлээр илэрч байдаг.

Өсвөр насныхны хүүхэд төрх байдлын цаана байгаа “том хүн” болох, насанд хүрэх чиг тэмүүлэлд гарч байгаа өөрчлөлтийг нь багш, эцэг эхчүүд олж хараагүй, захирч тушаан буруу харьцсанаас болж зөрчил, үл ойлголцол үүсэж байдаг. Өсвөр насанд гардаг үндсэн өөрчлөлт нь:

1. Бие бялдар биологийн өөрчлөлт (биеийн галбир, дүр төрх, бэлгийн хөгжлийн үйл ажиллагаа, бэлгийн хоёрдогч шинж тэмдгүүд илрэн гарах)
2. Сэтгэл зүйн өөрчлөлтүүд (өөрийн бие бялдар, оюун ухааны тухай бодох, үзэл санаагаа илэрхийлэх, дэлхий ертөнц, нийгмийн тухай бодол эргэцүүлэл хийх гэх мэт.)

Өсвөр үеийнхнийг нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлтийг насны дараах 3 үе шатаар авч үзэх нь илүү үр дүнтэй гэж үзсэн байна.

Хүснэгт 1

Өсвөр насны хүүхдийн нийгмийн болон сэтгэлзүйн өөрчлөлт

	Эрт үе: 10-13 нас	Дунд үе: 14-16 нас	Хожуу үе: 17-19 (тогтмол биш)
Сэтгэл зүйн	Бие бялдрын тухай ойлголт өөрчлөгдөнө. Олны анхааралд байгаа мэдрэмжтэй. Ааш зан тогтворгүй. Хийсвэр мөрөөдөх бодит биш зорилго тавина. Ганцаар байх дуртай. Хөвгүүд илүү хувиа хичээмтгий байна.	Хийсвэрлэх сэтгэлгээ тогтоно. Өөрийн биедээ дасаж гадна төрхөө сайжруулах талаар их анхаарна. Үе тэнгийнхнээс хамаарал ихтэй. Эрсдэлд өртөмхий болно. Сэтгэл гутрах явдал их. Өөрийн болон бусдын сэтгэлийг илүү ойлгодог болно.	Оюуны болон үүрэг хариуцлагаа тодорхойдог чадвар бий болно. Эцэг эхийн болон бусдын шүүмжлэлийг хүлээж авах чадвартай Бие дааж шийдвэр гаргана. Эцэг эхийн үгэнд орно. Охид илүү хувиа хичээнэ.
Гэр нийгмийн	Бие даасан байдал, хараат байдлын хязгаарыг тогтоож эцэг эхтэйгээ зөрчилдөж эхэлнэ. Маргаанч зөрүүд. Хувийн нууц ихтэй болно.	Хяналт тавиулах дургүй болно. Үүнээс болж гэр бүлийн зөрчилдөөн үүснэ.	Ганцаарчилсан харьцааг илүү эрхэмлэдэг. Хувь хүний хувьд өөрийн бодит мэдрэмжтэй. Хүүхэд-эцэг эхийн харилцаа нь насанд хүрэгсдийн харилцаа болж өөрчлөгдөнө.
Үе тэнгийнхэн	Ижил хүйсийн найз нөхдийг эрхэмлэнэ. Ижил хүйсийн найз нөхөд олонтой болно.	Өөрийн гэсэн дүр төрхөө тодорхойлох хэрэгцээ нэмэгдэнэ. Үе тэнгийнхний нөлөө хамгийн их байна. Дарамт шахалтад орно. Мөн эсрэг хүйсийн найз нөхдийг хүсэмжилнэ. Бусдын анхаарлыг татах, улмаар болзоно.	Үе тэнгийнхний бүлгээс хувь хүмүүсийн хоорондын нөхөрлөлийг эрхэмлэнэ. Үе тэнгийнхний нөлөөнд автах нь багасна. Таалагддаг хүмүүсээс дотнын хүмүүсээ сонгоно.

“Өсвөр насны хүүхэд амьдралын туршлагаар хомс, юмны гадаад өнгөн талд автагдах, “том хүн” болох гэж яарах нь тамхи татах, архи дарс хэрэглэхэд хүргэдэг нь энэ насны зөрчил юм”. (Ичинхорлоо, 2012, х.34) Шилжилтийн энэ үед нь эцэг эх, багш нар өсвөр насны хүүхдүүдэд анхаарал тавьж, тэдний ертөнцийг ойлгож хамтран ажиллах чухал байна.

Мөн нийгмийн ижил түвшний байр сууринаас зан байдал, үйлээр нь үлгэрлүүлэн дэмжих, туслах, хамтран суралцах үйл ажиллагаагаар дамжуулан явуулах үе тэнгийнхний сургалт нь сургалтын үр дүнгийн судалгаанд ихэнхдээ маш их эерэг үзүүлэлттэй байдгийг (Dierdre Derrick, 2015, х.15) тэмдэглэсэн байна. Иймд өсвөр насны хүүхдийн чөлөөт цагийг бүтээлч байдлаар өнгөрүүлэхэд олон талт үйл ажиллагааг сургууль, багш, эцэг эхийн зүгээс зохион байгуулж, анхаарах хэрэгтэй.

Судалгааны үр дүн

ЕБС-ийн улирлын амралтын үеэр бус хичээл, сургалттай үед өсвөр насны хүүхдүүд чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж буйг хувийн болон улсын сургуулийн хүүхдүүдийн хүрээнд авч судаллаа.

Судалгаанд Улаанбаатар хотын ерөнхий

боловсролын 84, 110, “Оюунлаг” сургуулиудын өсвөр насны 110 сурагч хамрагдсан юм. Судалгааг асуулгын болон фокус бүлгийн ярилцлагын гэсэн хоёр аргаар авлаа.

Асуулга: ЕБС-ийн 90 хүүхдээс 4 нээлттэй, 4 хаалттай нийт 8 асуултаар судалгаа авлаа.

Судалгаанд хамрагдсан 90 хүүхдийн нас, хүйсийг тоон ба хувьчилсан үзүүлэлтээр ангилан харахад нийтдээ 44% эрэгтэй, 56% эмэгтэй, 13-18 насны хүүхдүүд хамрагдсан байна.

1. Чөлөөт цагийн талаарх ойлголт:

Судалгаанд хамрагдсан 90 хүүхдийн чөлөөт цагийг хэрхэн ойлгож байгаа асуудлыг судалж үзэхэд 45% нь амрах, дуртай зүйлээ хийж өөрийгөө хөгжүүлэх цаг гэж ойлгодог байхад, 33% нь зөвхөн дуртай зүйлээ хийх цаг, 13% нь өөрийгөө хөгжүүлэх, 9% нь ердөө амрах цаг гэж ойлгодог байна.


2. Нэг өдрийн чөлөөт цагийг судлахад:

Хичээлээс гадуур гардаг чөлөөт цаг 39% -д 3-4 цаг, 28%-д нь 1-2 цаг, 24% нь 5 ба түүнээс дээш цаг, 9% -д нь огт чөлөөт цаг гардаггүй хэмээн хариулсан байна. Энэ үзүүлэлт нь улсын сургуульд сурдаг хүүхдүүдийн чөлөөт цагийн тухайд дунджаар 3-4 цаг хангалттай гарч, харин хувийн сургуулийн хүүхдүүд өдөртөө 6-7 цаг үндсэн хичээлдээ суугаад, хичээлийн дараа өдөр бүр 2 цагийн давтлага,

- гэртээ хариад гэрийн даалгавар хийх цаг гээд чөлөөт цагаар хомс байдаг нь судалгаагаар харагдлаа.
3. Чөлөөт цагаа хэр үр бүтээлтэй өнгөрүүлдэг вэ? гэсэн асуултаас харахад судалгаанд оролцогчдын 15% нь чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд байнга, 39% нь ихэвчлэн, 46% нь заримдаа анхаардаг гэж хариулсан байдлаас харахад судалгаанд оролцогчдын 54% нь тодорхой зорилготой байгаагийн илрэл юм.
 4. Чөлөөт цагийг зөв өнгөрүүлэхэд өсвөр насны хүүхдүүдэд сургууль, эцэг эхийн зүгээс хандсан анхаарал сул байгааг мөн өсвөр насны хүүхдүүд найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ илүү ойр байдаг нь харагдаж байна.
 5. Чөлөөт цагаа ихэвчлэх хаана, хэрхэн өнгөрүүлдэг вэ? гэсэн асуултад 90 оролцогчоос 2 нь хариулаагүй. 61,2% нь гэртээ, 21,5% сургууль, 17% гадуур өнгөрүүлдэг байна. Энэхүү судалгаа нь өвлийн хичээлийн үеэр хийгдсэн учраас хүүхдүүдийн чөлөөт цагаараа хийж буй зүйлүүд нь нэлээд явцуу байж болох талтай.
 6. Танд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд юу их саад болдог вэ /3-ыг нэрлэнэ үү/ гэсэн асуултад давхардсан тоогоор хамгийн их саад болдог зүйлс нь гэрийн даалгавар, гэр бүлийн гишүүд, зурагт үзэх зэргийг нэрлэжээ.

График 1

Чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд саад болдог зүйлс




Энд хүүхдүүдэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд гэрийн даалгавар хамгийн их саад болдог гэж хариулсан нь ЕБС-ийн хичээлүүдийн даалгаврын тухайд хүүхдэд ноогдох ачааллыг тооцож үздэггүй гэдгийг илэрхийлж байна.

7. Таны чөлөөт цагаараа хийх хамгийн дуртай зүйлс

График 2

Чөлөөт цагаараа хийх дуртай зүйлс




Хүүхдүүдийн хийх дуртай зүйл нь PC тоглох, сагс тоглох, кино, зурагт үзэх, найз нартайгаа байх, интернет гэх мэт нэрлэсэн байна. Үүнээс харахад өсвөр насны хүүхдэд чөлөөт цагаа өнгөрүүлэх өөр орчин, үйл ажиллагаа хомс байгааг судалгааны дүн харууллаа.

8. Танд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хэрэгцээтэй зүйл:

Зураг 3

Чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хэрэгцээтэй зүйлс



Нийт 16 зүйл нэрлэснээс энэ насны хүүхдүүдэд тайван орчин, тоглох газар, цаг хугацаа гэх зүйл (давхардсан тоогоор 35%-ийг эзэлж байна) илүү хэрэгцээтэй болох нь харагдаж байна. Фокус бүлгийн ярилцлага: ЕБС-ийн өсвөр насны 20 хүүхдээс урьдчилан бэлтгэсэн 6 асуултын дагуу ярилцлагыг авлаа.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг нас, хүйсээр нь авч үзвэл 15% нь 13 настай, 20% нь 14 настай, 35% нь 15 настай, 30% нь 16 настай өсвөр насны хүүхдүүд хамрагдсан байна. Судалгаанд 8 эрэгтэй хүүхэд хамрагдсан бөгөөд 5% нь 13 настай, 10% нь 14 настай, 15% нь 15 настай, 10% нь 16 настай хүүхдүүд оролцсон. Судалгаанд 12 эмэгтэй хүүхэд хамрагдсан бөгөөд үүний 10% 13 настай, 10% 14 настай, 20% 15 настай, 20% нь 16 настай хүүхдүүд оролцсон.

Чиний чөлөөт цагт найз нөхөд чинь хэрхэн нөлөөлдөг вэ? гэсэн асуултад:

Судалгааны дүнгээс харахад 20 хүүхдийн 30% нөлөөлдөггүй, үлдсэн 70% хамт гадуур гадуурх гарах, бие биеийнхээ гэрт очих сонирхолтой мэдээлэл солилцон найзуудтайгаа уулзаж сонирхолтой байдлаар цагийг өнгөрүүлдэг гэж үзэж байхад зарим сурагчид утсаар ярих, гадуур явах нь цагаа үр дүнгүй өнгөрөөхөд хүргэдэг хэмээн хариулсан.

Чөлөөт цагийг яавал илүү үр дүнтэй өнгөрүүлж болох вэ? гэсэн асуултад

Сонирхлынхоо дагуу хүссэн зүйлээ хийж өөрийнхөө авьяас, оюун ухаан, бие бялдраа хөгжүүлэхэд анхаарч өнгөрүүлбэл илүү үр дүнтэй. Заримдаа цагийг үр дүнгүй өнгөрөөснөөр гэрийн даалгавраа хийх болон орон гэрийн ажилдаа ч тусалж чаддаггүй хэмээн хариулжээ.

Хүүхдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлж болох үнэ төлбөргүй ямар нэгэн газар байдаг уу? Байдаг бол хаана ямар төрлийн үйл ажиллагаа явуулдаг газрууд байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 35% нь сайн мэдэхгүй

байна, 40% нь номын сан, 10% нь бямба гарагт “English Speaking Club” гэдэг англиар ярьдаг клуб байдаг гэж хариулсан байна. Мөн “үнэ төлбөргүй гэвэл Есүсийн хэдэн сургалт байдгийг л мэдэх юм байна”. “Би 2 сар зургийн дугуйланд нь явсан. Ер нь хүүхдийг дэмжиж өгөх ёстой. Аав ээж нь боломжгүй хүмүүс зөндөө байдаг. Хүүхэд нь сургалтад явах хүсэлтэй ч төлбөрийн улмаас чаддаггүй тийм болохоор төлбөргүй сургалтууд нэвэл сайн байна” гэсэн санал хэлж байсан.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаардаг уу? Та нарт эцэг эхчүүд нь чөлөөт цагаа өнгөрүүлэхэд ямар нэгэн санал зөвлөгөө өгдөг үү? гэсэн асуултад дүн шинжилгээ хийхэд судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 45% нь эцэг, эх нь огт анхаардаггүй, 15% нь байнга анхаарч дугуйлан, секц, клубт явуулдаг. Ихэвчлэн эцэг, эхчүүд хичээл хий, утсаа оролдохоо боль, ном унш, амралтаараа сургалтад яв, давтлага ав гэх мэтчилэн санал зөвлөгөөг хэлдэг. Мөн анги дэвших, эсвэл шалгалт дөхөөд ирэхээр л анхаардаг. Ямарваа нэгэн хэлний дамжаа урлагийн дугуйланд явахыг санал болгодог гэсэн хариулт нийтлэг байлаа. Хүүхдүүдийн саналаас ишилбэл: “Мэдээж өөр өөр байдаг. Хүүхдээ дэмждэг нэгэн байхад тоодоггүй хүмүүс ч байдаг миний бодлоор хүүхэд юу хиймээр байна яг сонирхол нь юу вэ? гэдгийг, мөн хүүхдээ их сайн ойлгох хэрэгтэй. Аав ээж нь хүүхдээ ойлгохгүй байвал ээж ааваасаа хөндий, зожиг болдог. Ер нь эцэг, эхчүүд яг өөрийнхөөрөө шийдээд хүүхдээ сонсдоггүй. Хүүхдүүдээ сонсох л хэрэгтэй тэгээд хүүхдийнхээ ирээдүйн мэргэжлийн дагуу сургалт дамжаанд явуулах нь зөв байх” /03 кодтой хүүхдийн ярилцлагаас/ гэх мэт санал хүүхдүүд хэлж байсан.

Сургууль, багшийн зүгээс ямар ажлуудыг зохион байгуулах хэрэгтэй байна вэ?

Судалгаанд хамрагдсан 20 хүүхдийн 75% нь хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх дараах зүйлсийг санал болгосон.

- Амьдралын талаарх ойлголтоор багш нар өөрийн туршлагаасаа лекц унших
- Хүүхэд, сургууль, багш, эцэг эх хамтарсан үйл ажиллагаа явуулах
- Бидний ирээдүйд туршлага болохуйц амжилттай яваа хүмүүсийн лекц, зөвлөгөө
- Дунд, ахлах ангийнхныг хамарсан хөгжилтэй уралдаан тэмцээн зохиох
- Мэдлэг, оюун ухаан сорьсон хөгжөөнт тэмцээн зохиох
- Аялал зугаалга, салхинд гарах, зохиол бичих зэрэг хүүхдүүдэд үр өгөөжтэй байх бие бялдар, оюун ухааныг нь хөгжүүлэх арга хэмжээ зохиох гэх мэт санал хэлсэн.

Дүгнэлт

Өсвөр насны хүүхдийн хөгжил төлөвшилд нөлөөлөх тодорхой ажлуудыг БСШУСЯ болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулдаг хэдий ч хүртээмжтэй бус байна. Тухайлбал: БСШУСЯ-аас хүүхдийг хөгжүүлэх зорилго бүхий “Ном”, “Авьяас” гэх мэт хөтөлбөрүүд хэрэгжүүлж, сургуулиудад ангийн болон дижитал номын сан, дугуйлан секц, клубүүд ажиллаж байгаа хэдий ч хүүхэд бүрд хүртэх багш цөөн, нэг ангид ногдох хүүхдийн ачаалал их байгаатай уялдан хүүхэд бүр хамрагдах боломжгүй байна.

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ авьяас чадварыг нээн илрүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхийн тулд дугуйланд өгөх хүсэлтэй байдаг ч, сургуулиас гадуур ихэнх дугуйлан, секц, клубүүд төлбөртэй байдаг, хаана ямар дугуйлан секц хичээллэдэг талаар мэддэггүй учраас тэр бүр өгч чаддаггүй байна.

Магадгүй, хүүхэд тань гэртээ, эсвэл сургууль дээр байхгүй бол гудамжинд юм уу эсвэл РС тоглоомын аль нэгэнд байхаас өөр орчин байхгүй хомс байна. Цаашид өсвөр насны хүүхдийн чөлөөт цаг, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, үр бүтээлтэй өнгөрүүлэх арга зам, чөлөөт цагаар дамжуулан хөгжиж, төлөвших боломж зэргийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нь харагдаж байна. Иймд судалгаанаас үндэслэн дараах саналыг дэвшүүлээ.

1. Эцэг, эхчүүд өсвөр насны хүүхдийн бие бялдар, сэтгэлзүйн, танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг анхаарч тэднийг зөв бие хүн болон төлөвшихөд:
 - Ярилцахыг хүссэн үед нь цаг гарган тэднийг сонсдог байх (тайван анхааралтай, сэтгэлийг нь ойлгон эелдэг байдлаар ярилцах)
 - Өөрсдийнх нь сонголтыг дэмжиж урам өгөх

- Гэр бүлийн шийдвэр гаргах, төлөвлөх асуудалд оролцуулан дэмжиж байх нь гэр бүлийн үнэт зүйлийг ойлгосон, зорилготой, өөртөө итгэлтэй, өөрийн гэсэн үзэл бодолтой зөв хүн болон төлөвшихөд чухал хэмээн үзэж байна.

2. Тодорхой судалгаанд суурилж хичээлийн дараа олон чиглэлээр амьдралд бэлтгэх, тэдэнд дэлхий ертөнцийг танин мэдэх мэдлэг чадварыг эзэмшүүлэх, бие хүн төлөвшүүлэх өргөн боломжийг хангаж, хүүхдийг хөгжүүлэн чөлөөт цагийг нь зөв өнгөрүүлэх зорилго бүхий хөтөлбөрүүд боловсруулах, түүндээ өсвөр насныхны оролцоог нэмэгдүүлэн, үйл ажиллагаандаа татан оруулж өөрсдөөр нь удирдуулан ажиллуулж болох юм.

Ашигласан материал

- Ичинхорлоо, Ш. (2012). Хүүхдийн хөгжил. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. Мандах, Д. (2013). Боловсролын социологийн удиртгал. Улаанбаатар
- Жамц, Л., Санжжав, Д. (2011). Ерөнхий сэтгэл судлал. Улаанбаатар
- Dierdre Derrick (2015). Engaging Students as Tutors, Trainers, and Leaders. English Teaching Forum, 12 <http://socialwork.blog.gogo.mn/read/entry402681> http://www.nso.mn/content/1220#.Vpxtr_196M8 <http://my.clevelandclinic.org/childrens-hospital/health-info/ages-stages/adolescence/hic-adolescent-development.aspx> <http://www.chemn.moh.gov.mn>